



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 51

Шүүрээтэй

Төлөөлөн удирдах зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 20 дугаар зүйлийн 20.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.12, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Тохижилт үйлчилгээний алба" ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

| | | |
|-----------------------|---------------|---|
| Зөвлөлийн дарга: | Б.Гүррагчаа | Идэр голын сав газрын захиргааны мэргэжилтэн |
| Гишүүд: | С.Болдбаатар | Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга |
| | С.Даваадорж | Баяжуулагч инженер |
| | О.Түвшинтулга | Баяжуулагч инженер |
| Нарийн бичгийн дарга: | Г.Насанжаргал | Тохижилт үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын ХАБ, нярав |

2. Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль, журамд заасан эрх үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 86 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА  Б.ГАНБАЯР

